

## ЭДИЙН ЗАСГИЙН ГЛОБАЛЧЛАЛ: ХЯТАДЫН БАЙР СУУРЬ

*Ц.Баатар\**

Хятадын Ерөнхийлөгч Зян Зэминь 2000 оны 11 дүгээр сарын 16-нд Брунейд болсон АПЕК-ийн хуралдаан дээр хэлсэн үгэндээ улс үндэстнүүд эдийн засгийн глобалчлалд оролцох явдал эдийн засгийн хөгжлийн “бодит шаардлага” хэмээн тэмдэглэсэн. Тэрээр глобалчлалын олон улсын харилцаанд үзүүлж буй нааштай нөлөөний талаар тэмдэглэхдээ “үндэстнүүд болон бүс нутгийн хоорондын ойр дотно эдийн засгийн болон технологийн харилцаа холбоо нь” “дэлхий дахинд энх тайван, тогтвортой байдлыг бэхжүүлэхэд нааштай нөлөө” үзүүлж байна гэсэн билээ. Харин Хятадын санаа зовниж буй асуудлын талаар Зян Зэминь хэлэхдээ глобалчлал нь улс үндэстний хооронд болон тэдгээрийн дотоодод эдийн засгийн тэгш бус байдлыг нэмэгдүүлэх зэргээр сөрөг үр дагавар авч ирж байна гэв. Тэрээр мөн глобалчлалын болзошгүй улс төр, соёлын сөрөг нөлөөний талаар Хятад мөн санаа зовниж байгааг дурдсан юм. Тэрээр “зарим орнууд”-ыг “эдийн засгийн глобалчлалыг ашиглан өөрсдийн үзэл бодол, эдийн засаг, нийгмийн системээ бусад орнуудад тулгаж байна” хэмээн буруутгав.

Глобалчлалын талаархи Зян Зэмений хоёрдмол санаа нь нэг талаар, Хятадын албаны олон хүмүүс болон судлаачид глобалчлал нь Хятадад сөрөг нөлөө үзүүлж болзошгүй хэмээн болгоомжилж байгаа, нөгөө талаар Хятад глобалчлалаас ухрах боломжгүй зөвхөн урагшаа явахаас өөр зам байхгүй гэдгийг мэдэрч байгаагийн илрэл гэж үзэлтэй. Хятадын шинэ удирдлага улс орон нь эдийн засгийн глобалчлалын үйл явцад оролцож байгааг хүлээн зөвшөөрөхийн зэрэгцээ түүний болзошгүй сөрөг үр дагаварын талаар ч мөн ярьж байгааг тэдэглэх нь зүйтэй болов уу. Гэвч энэхүү гол зөвшил нь глобалчлалын талаархи яриа, сэтгэл хөөрлийг эцэс болгож чадахгүй байна. Ихэнх нь биш юмаа гэхэд олон нэр бүхий хятад хүмүүс өнөөгийн байдлын талаар сэтгэл дундуур байна. Өөрчлөн байгуулалтын талынхан Хятад глобалчлалын шаардлагын дагуу хурдан өөрчлөгдөхгүй байна хэмээн шүүмжилж харин үндсэрхэг консерватив үзэлтэнгүүд глобалчлал Хятадын зан заншил, тусгаар тогтнол, бие даасан байдалд занал учруулна хэмээн үзэж глобалчлалын үйл явцад гүнзгий орохгүй байхыг шаардаж байна.

Энэхүү өгүүлэлийг зохиогчийн Хятадын албаны хүмүүс Монгол Улсад айлчлах явцад Олон Улс Судлалын Хүрээлэнгийн эрдэмтэдтэй хийсэн уулзалт, дугуй ширээний яриа болон олон улсын эрдэм

\*Ц.Баатар - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D), дэд профессор

шинжилгээний бага хуралд оролцож байсан Хятадын судлаачидтай глобалчлалын талаар хувиараа хийсэн чөлөөт ярилцлага, санал солилцох явцад хийсэн хувийн дүгнэлтэдээ дээр тулгуурлан тэрлэв. Түүнчлэн Америкийн хятад судлаач Banning Garrett-ын судалгааг ч энд өргөн дэлгэр ашиглав. Санал солилцсон хүмүүс янз бүрийн давхаргын хүмүүс. Түүний дотор засгийн газрын байгууллагууд, судалгааны институтууд болон бизнесийн хүмүүс байлаа. Зарим хүмүүс Хятадын улс төрийн удирдагатай ойр холбоотой байгууллагуудын төлөөлөгчид байсныг энд тэмдэглэж байна. Тухайлбал, Хятадын удирдагчдад илтгэлээ шууд танилцуулдаг Төрийн Зөвлөлийн дэргэдэх Орчин үеийн олон улсын харилцааны Хятадын Институт, Хятадын Гадаад хэргийн Яамны дэргэдэх Олон улсын судлалын хүрээлэн, Төрийн Зөвлөлийн дэргэдэх Хөгжлийн судалгааны төв, ХКН-ын Төв Хорооны дэргэдэх Намын Төв Институт болон Нам дахь өөрчлөлт шинэчлэлийн талтай ойр холбоотой төрийн бус байгууллага болох Хятадын Шинэчлэлийн Форум зэргийг нэрлэж болох юм. Мөн Хятадын Нийгмийн Шинжлэх Ухааны Академийн хүрээлэнгүүд болох Дэлхийн эдийн засаг, улс төр судлалын хүрээлэн, Ази, Номхон далайн судлалын хүрээлэнгийн англи хэлээр гардаг судалгааны материал, албан бус холбоотой эрдэмтэдтэй санал солилцож өөрт төрсөн хувийн сэтгэгдэлээ ямар нэгэн ишлэл зүүлтгүйгээр энд сийрүүлэхийг оролдов.

Миний уулзаж санал бодлоо солилцсон ихэнх хүмүүс эдийн засгийн өөрчлөлт, шинэчлэлийг гүнзгийрүүлэх, гадаад ертөнцөд өргөн нээлттэй байхыг дэмжиж байв. Олонхи хүмүүс өндөр мэдлэг боловсролтой Хятадын дотоод дахь яриа хэлцээний талаар мэдлэг хүмүүс байсан тул глобалчлалын эсрэг, ихээхэн шүүмжлэлтэй ханддаг хүмүүсийн үзэл бодлын талаар үнэлж баршгүй мэдээлэл өгсөн юм.

Энэхүү өгүүлэл нь глобалчлалын талаар Хятадын хэвлэлд гарсан зүйлийг системтэйгээр судлах буюу Хятад Дэлхийн Худалдааны Байгууллагын /ДХБ/ гишүүн орон болсноос хойшхи Хятад оронд гарч буй өөрчлөлт шинэчлэлийн асуудлын талаар судлах зорилго тавиагүй юм. Харин өндөр боловсролтой хувь хүмүүс глобалчлалын талаар юу гэж боддог, юунд тэргүүн зэргийн ач холбогдол өгч байгаа талаар энд өгүүлэхийг хичээв. Энэхүү өгүүлэлт эхлээд глобалчлалын талаархи Хятадын дотоодод өрнөж байгаа яриа хэлцээний тухай түүний дотор Хятадыг цаашид глобалчлалд гүнзгий орохыг эсэргүүцэж байгаа цөөнхийн үзэл бодлыг ч мөн ямар нэгэн хэмжээгээр авч үзэх оролдлого хийлээ. Үүний дараа глобалчлалын нөлөөгөөр Хятадад тулгарч байгаа эдийн засаг, улс төр, нийгмийн асуудлууд түүнийг шийдвэрлэхийн төлөө Хятадын засгийн газраас авч хэрэгжүүлж буй янз бүрийн арга хэмжээ, алдаа дутагдлын талаар өгүүлнэ. Төгсгөлд нь глобалчлалыг дэмжиж байгаа гол үзэл бодлод сөрөг нөлөө үзүүлж болох зүйлийн талаар авч үзлээ.

### **Глобалчлалын талаархи хуваагдмал үзэл бодол**

Анхандаа Хятадын ихэнх албаны хүмүүс, эдийн засагчид глобалчлалыг гол нь эдийн засгийн үйл явдал хэмээн үзэж байсан бөгөөд харин сүүлийн гурван жилийн байдлыг авч үзвэл тэдний үзэл бодол нэлээд нарийн төвөгтэй ээдрээтэй болж байна. Сэхээтнүүд болон албаны хүмүүсийн ихэнх нь глобалчлалын үйл явдлыг бүхэлд нь ашигтай хэмээн бүрэн дүүрэн дэмжиж байсан үзэл бодлоосоо ухарч эхээд байна. Урьд өмнө тэдний дунд глобалчлалын талаар ноёрхож байсан өөдрөг үзэл бодол 1997 оны Зүүн Азийн санхүүгийн хямралын түүний зарим Зүүн Азийн орнууд тухайлбал Индонез зэрэг орнуудад үзүүлсэн нөлөө зэргээс үүдэн эргэлзээнд орж эхлэв. Энэхүү үйл явдал нь Хятадын ихэнх сэхээтэн, албаны хүмүүсийн дунд глобалчлалын эдийн засгийн нөлөөний талаар эргэлзээ төрүүлэх үндэслэл болжээ.

Глобалчлалын тухай яриа 1999 оны эхээр АНУ, НАТО Югослав руу довтолж Белград дахь Хятадын ЭСЯ-ыг андуурч бөмбөгдсөнөөс үүдэн бүр ч зөрчилтэй болж ирсэн юм. Олонхи хятад хүмүүсийн үзэж байгаагаар АНУ нь глобалчлалын цорын ганц гол дэмжигч, түүний үр шимийг хүртэгч төдийгүй АНУ-ын бодлого стратегийн гол зорилго нь дэлхийд ноёрхолоо тогтоох үүднээс глобалчлалын эдийн засаг, соёл, нийгмийн үр дагаврын талаар анхаарал тавих явдлаа эрчимжүүлж байна гэж үзэж байна. Энэхүү үзэл бодол дэлгэрсний нөлөөгөөр глобалчлалын тухай яриа Хятад руу чиглэсэн АНУ-ын стратеги болон түүний эсрэг Хятадын бодлого ямар байх ёстой вэ гэсэн сэтгэлийн хөөрөлд автагдсан яриа өрнөх болсон гэнэ. Хятадын олон улсын харилцааны мэргэжилтэнүүд, нийгмийн шинжлэх ухааны эрдэмтэд болон бусад судлаачид, арми, нам, хэвлэл мэдээллийн консерватив үзэлтнүүд глобалчлалын үйл явцын улс төр, соёл, социологи, болон эдийн засгийн үр дагаврын талаар ихээхэн ярих болжээ. Яриа хэлцээний гол нь глобалчлал Хятадад болзошгүй аюул авч ирэх юм гэсэн дүгнэлтийг тэд хийж байна.

### **Глобалчлалыг дэмжиж буй гол чиглэл**

Дээр дурдсан таагүй үзэл бодол байгаа хэдий ч Хятадын удирдагчид, албаны хүмүүс болон судлаачдын үзэл бодлын гол ноён нуруу нь глобалчлал нь аюул учруулах тал байгаа боловч Хятад түүнд оролцох нь зайлшгүй бөгөөд өөр зөв зам байхгүй гэж үзэж байна. Энэхүү үзэл бодлын талаар нэгэн судлаач "Глобалчлалын хандлагыг дагасан орон хөгжих бөгөөд харин түүнийг сөрвөл тухайн орон ганцаардаж амжилтанд хүрч чадахгүй болно" гэж хэлж байна. Дэлхийн эдийн засаг, улс төрийн хүрээлэнгийн нэгэн ахлах мэргэжилтэн Хятадын гол чиг бодлого ямар байх ёстой талаар "хүссэн хүсээгүй бид глобалчлалын үйл явцад оролцох ёстой" гэж хэлж байна. Мөн өөр нэгэн судлаач

Хятадын удирдагчид “глобалчлал ямар ч сөрөг үр дагавар авч ирсэн Хятад орон глобалчлалын замаар урагшлах ёстой. Өөр ямар ч зам байхгүй” гэдгийг мэдэж байгаа гэж хэлж байна.

Энэхүү үзэл бодол баримтлагчид Хятад шаардлагатай арга хэмжээ авч чадвал глобалчлалын сайн нөлөө сөрөг нөлөөнөөс илүү гэж үзэж байна. Дэлхийн эдийн засаг, улс төрийн хүрээлэнгийн ахлах судлаачийн үзэж байгаагаар глобалчлалын нөлөөгөөр “нийгмийн тогтвортой байдал, зан заншил болон уламжлалт сэтгэлгээ, соёл зэрэгт өөрчлөлт гарах, улс төрийн шинэчлэл хийх зэрэг бэрхшээл гарах боловч глобалчлалаас хүртэх юм ч бас их байна”. Тэрээр Ерөнхийлөгч Зян Зэминь болон Ерөнхий сайд асан Жу Рунжи нар хэд хэдэн удаа хэлсэн үзэл бодол бол “хоёр талдаа иртэй сэлэм” юм гэж тэмдэглэсэн байна. Гэхдээ глобалчлалын талд байгаа судлаачид, албаны хүмүүс улс орнууд үндэснийхээ бодлогоор глобалчлалын сөрөг нөлөөг арилгаж болно гэж үзэж байна. Шанхайн Олон улсын эдийн засаг, худалдааны хүрээлэнгийн судлаач глобалчлалын сөрөг нөлөө нь түүнийг гаргахгүй байх талаар улс орон хэрхэн бэлтгэснээс хамаарна гэж үзэж байна. Түүний хэлж байгаагаар энэхүү санал бодлыг Хятадын өндөр хэмжээний удирдлагууд хүлээн зөвшөөрч байгаа ажээ.

Гол судлаачид Хятадыг глобалчлалын үйл явцын сөрөг нөлөөнөөс хамгаалах арга хэмжээ авч болох боломжтой талаар тэмдэглэхийн сацуу глобалчлалаас хөгжилтэй орнууд, ялангуяа АНУ л хөгжиж байгаа орнуудаас илүү ашиг хонжоо олж байгаа талаар бичиж байна. Хятадын Төрийн Зөвлөлийн Хөгжлийн судалгааны төвийн ахлах эдийн засагчийн үзэж байгаагаар “Өнгөрсөн туршлагаас үзэхэд глобалчлалаас хөгжиж байгаа орнууд нэг их хожихгүй байгаа” аж. Уг эдийн засагчийн үзэж байгаагаар сүүлийн 20 жилд хөгжиж буй болон хөгжилтэй орнуудын хөгжлийн зааг ялгаа улам нэмэгдэж байгаа хэдий ч “Дэлхийн Банк болон бусад олон улсын байгууллагуудын үзэж байгаагаар Хятад нь глобалчлалаас хожиж байгаа хөгжиж буй цөөхөн орнуудын нэг” юм байна. Хятадын Гадаад хэргийн Яамны дэргэдэх Олон улсын судлалын хүрээлэнгийн өөр нэг ахлах эдийн засагчийн үзэж байгаагаар Хятад нь өнгөрсөн 5 жилийн хугацаанд хамгийн их гадаадын шууд хөрөнгө оруулалт өөртөө оруулж байгаа (2003 онд 60 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт авсан), глобалчлалын шаардлагаар өөрийн эдийн засгийн бүтцийг сайжруулж Хятадын корпорациуд доод зэрэглэлийн барааны үйлдвэрлэлээс дунд зэрэглэл болон технологийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх болоод байгаа юм байна. Тэрээр “хэрэв Хятад глобалчлалын үйл явцад оролцоогүйсэн бол ийм амжилтад хүрч чадахгүй байсан бөгөөд харин глобалчлалын үйл явцад оролцсоны ачаар Хятад зөвхөн гадаадын шууд хөрөнгө өөртөө оруулах төдийгүй

бас өндөр технологи, менежментийн арга барилаас суралцаж байна гэж үзэж байна. Түүний үзэж байгаагаар хамгийн чухал нь Хятад глобалчлалд оролцсоноороо гадаад ертөнцийн талаархи үзэл баримтлалд нь өөрчлөлт гарч байгаа ажээ.

Түүнээс гадна глобалчлалын үр өгөөж Хятадын хувьд зөвхөн эдийн засгийн салбараар хязгаарлагдахгүй гэж үзэж байна. Хятадын удирдлага глобалчлалын нөлөөгөөр тулгарч болох асуудлыг шийдэх амжилт нь эдийн засгийн бус асуудлууд, тухайлбал, Тайваны асуудлаас ихээхэн хамаарна гэж үзэж байна. Шанхай хотын нэгэн судлаачийн үзэж байгаагаар Хятадын хувьд Тайваны асуудлаас илүү “хамгийн том асуудал” бол ДХБ-д элсэн орсны дараа глобалчлалын нөлөөгөөр тулгарах асуудлыг хэрхэн шийдэх асуудал юм байна. Түүний үзэж байгаагаар Хятад глобалчлалын нөлөөгөөр тулгарах асуудлыг амжилттай шийдвэрлэж эдийн засгаа ойрын 5-10 жилд хөгжүүлж чадвал “нэг Хятад” зарчмын үндсэн дээр Тайваньтай тогтвортой харилцаанд хүрч улмаар нэгдэх боломж бүрдэх юм байна. Нөгөө талаар, “хэрэв глобалчлалын үед өөрийн гэсэн замаа олж чадахгүй бол түүний эдийн засгийн хөгжил саарч эмх замбараагүй байдал үүсч энэ бүхний үр дүнд Тайвань тусгаар тогтнолоо олох илүү боломжтой болох юм” гэж тэрээр үзэж байна. Энэ үзэл бодол нь судлаачийн үзэж байгаагаар 2000 оны 10 дугаар сард хуралдсан Төв Хорооны тавдугаар бүгд хурлын илтгэлд тусгалаа олсон байна. Тэрээр Хятадын Ерөнхийлөгч Зян Зэминь АПЕК-ийн хуралдаанд хэлсэн үгэндээ глобалчлал нь дэлхийн эдийн засгийн интеграцчлал руу хөтөлж энх тайван тогтвортой байдлыг хангах хүч хэмээн дурдсан нь олон улсын харилцааны талаар болон түүний дотор Хятад, Тайваний харилцааны талаар байр сууриа илэрхийлсэн хэрэг юм гэж үзэж байна.

Гол судлаачид Хятад глобалчлалын ач тусыг хүртэж байгаа хэдий ч АНУ түүнээс ч илүү ашиг тус хүртэж байна гэж үзэж байна. Хятадын удирдагчид болон гол судлаачид, албаны хүмүүсийн үзэж байгаагаар АНУ дангаараа глобалчлалаас хожиж байгаа нь 1990-ээд оны эхээр тэдний хүлээж байсанчлан дэлхий олон туйлт олон улсын харилцааны чиглэл рүү хөгжөөгүйн нэг шалтгаан хэмээн үзэж байна. Глобалчлал нь эдийн засаг, технологи, улс төр, цэргийн салбарт АНУ-ын байр суурийг дэлхийн хүчний харьцаанд бэхжүүлж Америкийн стратегийн сонирхолын талаархи Хятадын санаа зовниж байсан байдал Косовогийн мөргөлдөөнөөс хойш улам нэмэгдэв. Америк судлалын хүрээлэнгийн ахлах судлаачийн хэлснээр глобалчлалын нөлөөгөөр АНУ дэлхийн эдийн засаг, цэрэг, улс төр, шинжлэх ухаан, технологийн салбарт давамгайлж байгаа цорын ганц орон болж дэлхийн улс төрийн хүчний тэнцвэр алдагдаж байгаа нь Хятадын хувьд томоохон асуудлын нэг болж байна

гэж Хятадын удирдагчид болон ХКН үзэж байгаа ажээ. Уг судлаачийн бодлоор Хятадын шинэ үеийн удирдагч Ху Зиньтоагийн сүүлийн үед хэлсэн үгнээс Хятадын удирдагчид АНУ өөрийн давуу байдлаа ашиглан “Хятадыг баруунчлах, хуваах бодлого явуулж байна” гэж үзэж байгаа нь ойлгомжтой байгаа юм байна. Хятадын удирдагчид, судлаачид, улс төрчдийн хувьд Хятад, Америкийн харилцааны энэхүү тэнцвэргүй байдал нь Хятад глобалчлалаас ухрах бус харин глобалчлалын олгож буй боломжийг ашиглан Хятадын хүчин чадлыг нэмэгдүүлэх ёстой гэж үзэж байна. Түүнээс гадна тэд глобалчлал нь дэлхий дахиныг америкчлах буюу АНУ, Хятадын хоорондын тоглоом гэж үзэхгүй байна.

### **Глобалчлалыг эсэргүүцэгч дуу хоолой**

Хятадын гол судлаачид, албаны хүмүүс глобалчлалын үйл явцыг зогсоох боломжгүй гэдгийг хүлээн зөвшөөрч байгаа боловч тэд Хятадад үйлдвэрийн болон яам газруудын зүгээс гадаад өрсөлдөөн нэмэгдэж, улс орныг дэлхийн эдийн засагтай улам гүнзгий интеграцчилж байгаагаас үүдэн глобалчлалыг эсэргүүцэх хүчин ч их байгааг хүлээн зөвшөөрч байна. Хятадын үндсэрхэг үзэлтэнгүүд болон зүүний үзэл баримтлагчид глобалчлалыг Хятадын тусгаар тогтнол, аюулгүй байдал, түүний соёл, нийгэм, өвөрмөц байдалд занал учруулж байна хэмээн үзэж анхааруулж байна.

Хятадын эдийн засаг цаашид дэлхийн эдийн засагтай интеграцчилагдах үйл явц гүнзгийрэх тэр хэмжээгээр үйлдвэрийн газрууд болон яамд нь глобалчлалын үйл явцад эсэргүүцэл үзүүлж чингэснээр ДХБ-ын олгосон хөнгөлөлт нь эргээд Хятадын эдийн засгийн ашиг сонирхолд занал учруулж болзошгүй хэмээн болгоомжилж байна. Ихэнх үйлдвэрийн газар, яам ДХБ-д гишүүнээр элсэх, глобалчлалын үйл явцад оролцох явдал нь удирдагчдын шийдвэр тул түүнээс татгалзах боломж байхгүй гэдгийг ойлгож байна. Иймээс тэд үйл ажиллагаагаа ДХБ-ын өмнө хүлээсэн Хятадын үүргийн биелэлтийг удаашруулах, глобалчлалын нөлөөнөөс үүдэн гарч буй гарз хохиролыг нь нөхөн олгохыг засгийн газраасаа шаардах зэрэгт гол нь төвлөрүүлж байна. Хөгжлийн судалгааны төвийн нэгэн ахлах эдийн засагч хэлэхдээ: “глобалчлалын нөлөөнөөс хожиж чадаагүй хэсэг засгийн газрыг туслах талаар ямар нэг арга хэмжээ авахыг хүлээж байгаа” юм байна. Түүний хэлснээр “дээрх байгууллага, яамдууд Дэлхийн Худалдааны Байгууллагад Хятад улс элссэн нь дээд удирдагчдийн шийдвэр тул түүнийг эсэргүүцээд юу ч олж авч чадахгүй. Харин түүний оронд Засгийн газраас туслалцаа дэмжлэг хүсч байсан нь дээр” гэж үзэж байна.

Хятадад глобалчлалыг хамгийн хурцаар эсэргүүцэх явдал үйлдвэрийн газрууд, эдийн засгийн яамдууд биш юм. Хамгийн хурцаар

эсэргүүцэгчид нь нам, хэвлэл мэдээлэл, арми, эрдэм шинжилгээний байгууллагууд, судалгааны байгууллагууд болон намын хүрээн дэх өсөн нэмэгдэж байгаа хэт зүүний талыг баримтлагчид байгаа юм. Эсэргүүцэл нь улам нэмэгдэж байгаа эдгээр хүчнүүд глобалчлалыг Хятадын бие даасан байдал, соёл, социалист зан төрхөд аюул занал учруулж байна гэж үзэж байна. Тэдний үзэж байгаагаар глобалчлал нь “Америкийн глобалчлал” бөгөөд АНУ глобалчлалыг ашиглан Хятадад улс төр, эдийн засаг, соёлын хувьд нөлөөлөх гэсэн оролдлого мэтээр дүрсэлж байна. Түүнээс гадна тэд ДХБ нь глобалчлалын гол зэвсэг хэмээн үзэж улс төр, эдийн засаг, соёлын зүгээс нь авч үзэж түүнд Хятад улс нэгдэн орсныг эсэргүүцэж байна.

Эдгээр эсэргүүцэгч хүчнүүд Хятад бусад орны гашуун туршлагаас сурах хэрэгтэй хэмээн үзэж байна. Тэд Орос, Зүүн Европ, Бразили болон Африкийн орнуудад тулгарч байгаа бэрхшээлүүд глобалчлалтай холбоотой хэмээн үзэж глобалчлалд оролцсоноос үүдэн дээрх орнууд бие даасан байдлаа алдаж “барууны Империалистуудын” гар хөл болж байна гэж үзэж байна. Зарим хатуу байр суурь баримтлагчид Хятадын өнөөгийн шинэ эрх баригчид ДХБ-д элссэн явдал Хятадын эрх ашгийг барууныханд худалдсан хэрэг хэмээн шүүмжлэх явдал ч гарч байв. Хятадын мэргэжилтнүүдийн үзэж байгаагаар глобалчлалын талаархи эдгээр шүүмжлэл нь Хятадын ЭСЯ бөмбөгдөлтөнд өртөгдсөн болон АНУ, НАТО Югослав руу довтолсноос хойш өргөн олны дунд ихээхэн дэмжлэг авсан бөгөөд АНУ-ын стратегийн зорилгын талаархи Хятадын эргэлзээг улам нэмэгдүүлсэн байна. Сүүлийн үед энэ байдал зөөлөрсөн. Үзэл бодолд ч нааштай хандлага ажиглагдах болсон. Террорист халдлагаас хамгийн их ашиг олсон орон бол өөр ямарч улс биш зөвхөн Хятад гэдгийг тэд нэгэн дугаар хүлээн зөвшөөрч байв. Мөн SARS Хятадын эдийн засагт бага зэрэг нөлөөлсөн нь мөн л глобалчлалын үр дагавар гэж тэд үзэж байв. Өөрөөр хэлбэл Хятадын сэхээтнүүд, судлаачид дэлхий дахинд интерацлал, харилцан хамаарал гүнзгийрч байгааг хүлээн зөвшөөрч байлаа.

Чухамхүү энэ үүднээс өнөөгийн Хятад глобалчлалд оролцсоноор бие даасан байдлаа алдаж, Хятадын социализмын үнэт зүйлс, тогтолцоонд занал учруулж байна гэсэн гадаад бодлогын үзэл баримтлалд зарим судлаачид нэлээд шүүмжлэлтэй хандаж байна. Хятадын шүүмжлэгчид Хятадын хувьд өнөөгийн бодлогоос өөр АНУ-ын бодлогын эсрэг Оростой ойртох, Тайванийг ойрын үед өөртөө нэгтгэхийн тулд хүч хэрэглэх зэрэг бодлого явуулахыг хүсч байна. Эдгээр хүчнүүд Хятадын эдийн засгийн өөрчлөлт, гадаад ертөнцөд өөрийгөө нээлттэй байх бодлого болон сүүлийн 20 жилийн Хятадын гадаад бодлогын суурийг тавьсан Дэн Сяопиний стратегийг ч эсэргүүцэж

байна. Хятадын үндэсний аюулгүй байдал, ялангуяа АНУ-тай цэргийн мөргөлдөөнд хүрч болох нөхцөл боломж зэргийг харгалзан Хятадын энх тайван, хөгжлийн орчинг урьдын адил авч үзэх боломжгүй гэж олон консерватив үзэлтэнгүүд үзэж байна. Үндсэрхэг үзэлтэнгүүд, хэт зүүнийг баримтлагчид Хятадын энх, тайван хөгжлийн стратегийг мөн эсэргүүцэж байна. Учир нь тэд Хятадын дээрх стратеги нь “глобалчлалын нэгэн адил зүйлийг эрхэмлэж байгаад оршиж байна” гэж үзэж байна. Глобалчлалыг эсэргүүцэгч үндсэрхэг үзэлтэнгүүд “энх тайван” гэсэн нэр томъёог Хятадын бие даасан байдлыг хамгаалахын тулд “хүч хэрэглэхгүй байх” гэсэн санаа хэмээн хүлээж авахгүй байгаа юм. Глобалчлалыг шүүмжлэгч зүүнийхний үзэж байгаагаар “хөгжил” гэсэн нэр томъёо нь “дотоодын нийт бүтээгдэхүүнийг өсгөх гэсэн санаа байгаа боловч тэгш байдлыг хангах гэсэн санаа илэрхийлэхгүй байна” хэмээн үзэж иймээс “орлогын ялгааг хүлээн зөвшөөрч байна” хэмээн шүүмжилж байна. Хятадын глобалчлалыг эсэргүүцэгчид “хэрэв бид бие даасан, эрх тэгш байдлыг эрхэм зорилгоо хэмээн үзвэл бид Тайванийг өөртөө нэгтгэхийн төлөө дайн хийх ёстой” гэж үзэж байна.

Энх тайван болон хөгжил, глобалчлалыг дэмжигч Хятадын албаны хүмүүс болон судлаачдаас ялгаатай нь дээрх үзэл санааг эсэргүүцэгчид Хятадын глобалчлалд орох үйл явцын хурдацыг сааруулж эдийн засгийн социалист салбарыг бэхжүүлэн өргөжүүлэх замаар социалист тогтолцоо руугаа эргэн орох ёстой гэж үзэж байна. Тэд “глобалчлал гэдэг маань баруунчлах үзэл бодол бөгөөд энэ нь зайлшгүй зүйл огт биш юм. Харин глобалчлал нь АНУ болон барууныхны дэлхийг ноёрхох, хөгжиж буй орнуудыг мөлжих арга юм” гэж үзэж байна. Тэд Зүүн Өмнөд Азийн санхүүгийн хямралын дараа Индонез руу зааж “баруунаас хараат байдал нь барууныхны даралт шахалтад илүү эмзэг болж байна” хэмээн хэлшгээж байв. Глобалчлалын эсрэг дээрх үзэл бодол дээрээ тулгуурлан тэд Хятадын социализмын суурь болсон улсын өмчийн үйлдвэрийн газруудыг өөрчлөн шинэчлэхийг эсэргүүцэж Хятадын эдийн засгийн сүүлийн үеийн сэргэлт төрийн өмчийн үйлдвэрийн газрыг шинэчлэхгүйгээр эдийн засгийн өсөлтийг хадгалж болж байна гэсэн нотолгоо хэмээн үзэж байна.

Хамгийн экстримист ялангуяа хэт зүүнийг баримтлагчид “Хятад өөрийн соёл, түүх, болон Маоизмын философи дээр суурилсан хөгжлийн өөрийн замыг олох шаардлагатай” гэж үзэж байна. Тэд “социалист өөрөө өөрийг хангах системд шилжих, түүгээр ч үл барам соёлын хувьсгалын үеийн ядуу гэхдээ тэгш нийгэмд” шилжихийг уриалж байна. Тэд Мао болон соёлын хувьсгалын үеийг эерэгээр үнэлж “Мао Хятадыг нэгтгэж, үйлдвэрлэлийн үндэс суурь тавьж, энгийн хүмүүсийн амьжиргааны наад захын шаардлагыг хангаж, империализмын эсрэг



тэмцэхэд нь Хятадад итгэл буй болгосон юм” хэмээн бичиж байна. Тэд Хятад соёлын хувьсгалын үед илүү дээр байсан гэж үзэж “тэр үед Хятад бие даасан, барууны эсрэг бие даасан байр суурьтай, чинээлэг биш ч гэсэн хүмүүс тэгш, сэтгэл санаа өөдрөг өнөөг бодвол ёс суртахууны хувьд хавьгүй дээр байсан” хэмээн бичиж байна. Эдгээр экстримист үзэл бодол харьцангуй цөөн тооны хэт зүүнийхний дотор байгаа хэдий ч тэдний үзэл бодлыг хүлээн авдаггүй, Хятад глобалчлалаас дайжиж социализм руу орох ёсгүй хэмээн үзэгчдийн дунд нөлөө үзүүлэхгүй гэх магадлал үгүй.

### **Хатуу шүүмжлэл нээлтэй, гэхдээ өөр замыг зөвшөөрөхгүй**

Мэдээлэл сайтай Хятадын судлаачдын үзэж байгаагаар глобалчлалыг шүүмжлэх явдал байгаа хэдий ч глобалчлалын талаархи “хоёр иртэй сэлэм”-ийн үзэл илүү ноёж байна. Энэхүү үзэл бодлыг ихэнх Хятадын удирдлага, албаны хүмүүс, эдийн засагчид, судлаачид баримталж байна. Хятадын Гадаад хэргийн Яамны дэргэдэх Олон улсын судлалын хүрээлэнгийн ахлах эдийн засагчийн үзэж байгаагаар глобалчлалыг шүүмжлэгчдийн үзэл санаа Хятадын удирдагчдад бас зохих нөлөө үзүүлж байгаа аж. Тэрээр шүүмжлэгчид мэдээж глобалчлал, ДХБ-ын хэрэгцээ шаардлагыг ойлгох зэрэгтэйгээ байгаа шүү хэмээн анхааруулсан байдаг. Глобалчлалыг эсэргүүцэгчид ихэнхдээ бодлого боловсруулах хүрээнийхний гадна байгаа тул Хятадын бодлогод нөлөөлж чадахгүй байгаа юм. Зарим их сургуулийн багш нар олны анхаарал татах үүднээс глобалчлалын талаар бичиж байгаа хэдий ч түүнд юманд нухацтай ханддаг эрдэмтэд ч, бодлого боловсруулдаг хүмүүс нэг их анхаарлаа хандуулахгүй байна. Хятадын удирдлага болон албаны хүмүүс Хятад глобалчлалд идэвхтэй оролцох ёстой гэдгийг хүлээн зөвшөөрч түүний зэрэгцээ глобалчлалын сөрөг нөлөөнөөс хамгаалах талаар ч анхаарах ёстой гэж үзэж байна. Түүнээс гадна Хятадын удирдлага, албаны хүмүүс гол анхаарлаа эдийн засгийн глобалчлал, түүний сөрөг үр дагаврыг даван туулахад хандуулж байгаа бөгөөд харин глобалчлалыг эсэргүүцэгчид глобалчлалын Хятадад үзүүлэх улс төр, нийгэм, соёлын нөлөөнд голлон анхаарч байна.

Хятадын удирдах болон албаны олон хүмүүс, судлаачид глобалчлалын эсрэг хүчний шүүмжлэлийг нааштай хүлээн авч байгаа хэдий ч тэдгээр шүүмжлэгчдийн санал болгож байгаа эдийн засгийн өөрчлөлтийг удаашруулах, улсын үйлдвэрийн газруудад илүү тулгуурлах, Маоизмын үеийн социализмд эргэн орох гэсэн эдийн засгийн стратегийг хүчтэй эсэргүүцэж байна. Хятадын судлаачдын үзэж байгаагаар Хятадын олон нийт глобалчлалыг шүүмжлэгчдийн барууны эсрэг үндсэрхэг үзлийг илүү

хүлээн авч байгаа хэдий ч тэд Хятадын бие даасан байдал, тусгаар тогтнол болон социализмын төлөө глобалчлалын эдийн засгийн эерэг нөлөөнөөс ухрахыг ч бас хүсэхгүй байгаа юм. Америк судлалын хүрээлэнгийн судлаачийн үзэж байгаагаар глобалчлалыг шүүмжлэгчид ард түмний дунд нэртэй байгаа хэдий ч хүмүүс хөгжил цэцэглэлийг хүсч байгаа аж. Өөр нэг судлаач глобалчлалыг шүүмжлэгчид ядуу хүмүүсийн төлөө, барууны империализмын эсрэг байгааг нь ард түмэн дэмжиж байна гэж тэмдэглэсэн байна. Гэхдээ ДХБ буюу байнгын хэвийн худалдааны харилцаа зэрэг тодорхой асуудлуудын тухайд ард түмэн шүүмжлэгчдийн үзэл бодлыг “бодитой биш”, “өөрчлөлтийн төлөө биш” хэмээн үзэж байна.

Гэхдээ глобалчлалыг эсэргүүцэгч үндэсэрхэг үзэлтэнгүүд болон хэт зүүнийг баримтлагчид Хятадын дотоод улс төрийн уур амьсгалд үлэмж нөлөө үзүүлж байна. Тэд интернет болон зарим сонин хэвлэлд нөлөөлөх замаар улс төрийн уур амьсгалд нөлөөлж байгаа аж. Тэд Хятад нь барууны орнуудаар хүрээлэгдэж түүний аюулгүй байдал улам муудаж байгаа тул үндэсний батлан хамгаалах болон улсын аюулгүй байдалд илүү хөрөнгө мөнгө зарах ёстой хэмээн дүрсэлж эрдэмтэд судлаачдын дунд айдас төрүүлж байна. Глобалчлалын төлөө байдаг АНУ-ын зарим эрдэмтэд интернетээр дамжуулан амь насанд нь занал хийсэн мэдээ хүртэл авч ихээхэн айх явдал ч гарч байна. Хятадын судлаачдын үзэж байгаагаар хэвлэл мэдээллийнхэн дуулиантай өгүүллэг, ном ихээхэн борлогддогийг ашиглан глобалчлалын эсрэг үндэсэрхэг үзлийг тарааж байна. Түүнээс гадна эдгээр үзэл нь нэг талаас, суртал ухуулгын газруудын дэмжлэгийг хүлээж, нөгөө талаас, удирдлагын зүгээс ч дээрх үзэл бодлыг нүхчин дарахаас зайлсхийж байгаа юм.

Глобалчлалын эсрэг хүчнийхэн хэдийгээр бодлого боловсруулагчдын хүрээний гадна байгаа хэдий ч тэдгээрийн нөлөө цаашдаа өсөн нэмэгдэх магадлал ч байгааг үгүйсгэх аргагүй. Хятадын зарим судлаачид, албаны хүмүүс Хятад ДХБ-ын өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх явцад ажилгүйдэл эрс нэмэгдэж, олон хүмүүсийн амьжиргаа доройтож нийгмийн тогтворгүй байдалд нөлөөлж барууны эсрэг үндэсэрхэг үзлийг дэвэргэж болзошгүй юм хэмээн ихээхэн санаа зовниж байгаагаар илэрхийлж байна. Хэрэв дээрх байдал үүсвэл глобалчлалыг эсэргүүцэгч үндэсэрхэг үзэлтэнгүүд болон хэт зүүнийг баримтлагчид олон нийтийн зүгээс Хятад социализм руу эргэн орох талаар дэмжлэгийг авч АНУ, Тайвань, Япон зэрэг орны эсрэг илүү хатуу бодлого явуулах талаар тэдний уриалж байгаа бодлого хэрэгжихэд хүрч болзошгүй юм. Гэхдээ энэ нь Хятад глобалчлалын сөрөг нөлөөг даван туулахад өөрийгөө хэр зэрэг бэлтгэх, АНУ болон Тайваньтай цаашдаа хэрхэн харилцах зэргээс ихээхэн хамаарах биз ээ.

### **Глобалчлалын тулгамдсан асуудлууд**

Хятадын албаны хүмүүс болон судлаачид глобалчлалын сайн, муу талын мэдлэг мэдээлэл нэмэгдлээ ч Хятад глобалчлалын үйл хэрэгт оролцох үүргээсээ хойш суухад хүргэхгүй гэж үзэж байна. Хятадын Олон улсын судлалын хүрээлэнгийн эдийн засагч “хэрэв Хятад эдийн засгийн хөгжлийн зөв зүйтэй стратеги боловсруулж, засгийн газар улс орныг гадаадад нээлттэй болгох бодлогыг удирдан чиглүүлбэл Хятад нь глобалчлалын олгож буй боломжийг эдийн засгийнхаа хөгжилдөө ашиглаж чадах болно” гэж үзэж байна. Хятад ДХБ-д элсэн орсноор эдийн засгийнхаа өөрчлөлтийг түргэсгэж ялангуяа Хятадад бие даасан шүүгчдийг буй болгоход ихээхэн тус дөхөм үзүүлж байна гэж ихэнх судлаачид үзэж байна. АНУ-д боловсрол эзэмшсэн, судалгааны хүрээлэнд ажиллаж байсан нэгэн хуульч “ДХБ-ын гол утга бол хуулийг дээдлэх явдал юм” гэж хэлж байна. Түүний үзэж байгаагаар, тухайлбал, өнөөгийн хийж байгаа олон зүйлүүд ямар ч гэрээ, контрактгүйгээр явагдаж байгаа бөгөөд харин ДХБ-д орсноос хойш бүх зүйл гэрээ, контракттай байх болох юм байна. Хятадын олон судлаачид, бизнесийн хүмүүс Хятад ДХБ-д орсноор засгийн газрын ажил илүү үр бүтээлтэй, ил тод болж эдийн засгийн системийн өөрчлөлтөд түлхэц өгч хууль, зохицуулалтын систем бэхжиж, гадаадын хөрөнгө оруулалт нэмэгдэж тэр хэмжээгээр Хятадын үйлдвэрлэлийг сайжруулах шинэ технологи, менежмент нэвтрэх боломжтой болно гэж үзэж байна.

Гэвч Хятадын олон судлаачид Хятад ДХБ-д элсэн орж дэлхийн интеграцлалд гүнзгий орсноор глобалчлалын нөлөөгөөр гарч болох эдийн засгийн олон тулгамдсан асуудлын талаархи шаардлагыг хангаж чадах эсэх талаар бас санаа зовж байна. Хятад ДХБ-д элссэнээр хожих бол алсдаа л үр дүн нь гарах бөгөөд эхэн үед Хятадын олон үйлдвэр аж ахуйн газрууд өрсөлдөөнийг дийлэхгүй хаагдах болно гэж тэд үзэж байна. Түүнээс гадна Хятадын зарим эдийн засагчид, судлаачид Хятад алсдаа тохиолдох тулгамдсан асуудалд бэлтгэгдээгүй, засгийн газар шаардлагатай арга хэмжээ авахгүй байна хэмээн ил тодоор шүүмжилж байна.

### **Хүчтэй өрсөлдөөний улмаас Хятадын үйлдвэрлэл хохирол амсах уу?**

Хятадын судлаачдын хөндөж байгаа хамгийн ноцтой асуудал бол өсөн нэмэгдэж, эрчимжиж байгаа гадаадын өрсөлдөөнийг Хятад сөрөн зогсож чадах уу гэдэг асуудал юм. Зарим үйлдвэрийн салбарууд, тухайлбал, бөс бараа, оёдол, өргөн хэрэглээний электрон бараа зэрэг нь илүү үр дүнтэй байх нөхцөл байгаа хэдий ч олон үйлдвэрийн салбар өрсөлдөөний улмаас ихээхэн хүнд байдалд орох болно гэж Хятадын эдийн засагчид үзэж байна. Хүнд байдалд орж болох өөр салбаруудад хөрөнгө мөнгө ихээхэн шаарддаг нефть химийн үйлдвэр, автомашины

үйлдвэр, мөн санхүү, телехолбоо, өндөр технологи шаардсан салбар, хөдөө аж ахуйн салбар орж байна. Тухайлбал, Хятадын Олон улсын судлалын хүрээлэнгийн эдийн засагч хэлэхдээ: “санхүүгийн үйлчилгээний салбарыг төрийн өмчийн байгууллагууд ноёрхож байгаа бөгөөд тэд ихээхэн хоцрогдсон байгаа. Тэд монополоо алдвал гадаадын корпорациудтай өрсөлдөх ёстой болно” гэжээ. Тэрээр улсын олон үйлдвэрийн газар дампуурах, хэмжээгээ багасгах буюу бүтцийн өөрчлөлт хийх шаардлага гарах бөгөөд ийм шаардлага гарсан тохиолдолд засгийн газрын зүгээс авч буй арга хэмжээ тэр бүр амжилттай байсангүй гэж мөн тэмдэглэжээ. Мөн зарим үйлдвэрийн газрууд хүчтэй өрсөлдөөнд бэлтгэж байгаа тухай ч ярьж байна. Тухайлбал, зарим холбооны компаниуд бага үнээр илүү сайн үйлчилгээ үзүүлж, утас тавих үйлчилгээ урьд өмнө хэд хэдэн сар шаарддаг байсан бол эдүгээ хоёр долоо хоног ч шаардах болж өөрчлөгдөж байгаа ажээ.

Зарим судлаачдын үзэж байгаагаар бусад хөгжиж байгаа орнуудтай харьцуулахад Хятадад бизнесийн зардал өсч байгаа тул олон улсын хүнсний барааны худалдаанд илүү оролцох шаардлага нэмэгдэж өрсөлдөх чадварын асуудал хурцаар тавигдаж байгаа юм байна. Хятадын өрсөлдөх чадвар сүүлийн хорин жилд нэмэгдэж байгаа хэмээн Хятадын судлаачид үзэж байгаа хэдий ч Шведийн судалгааны байгууллагын үзэж байгаагаар дэлхийн төвшинтэй харьцуулахад Хятадын өрсөлдөх чадвар буурч байгаа ажээ. Өөрөөр хэлбэл, хямд ажиллах хүч, хямд байгалийн баялаг, хөрөнгө оруулалт зэрэг нь Хятадын өрсөлдөх чадварыг удаан барьж чадахгүй гэсэн үг юм. Хятадад ажиллах хүчний өртөг нэмэгдэж газрын үнэ өсч дотоодын зах зээл өсөхгүй байгаа ажээ. Иймээс Хятадын үйлдвэрлэлийн бүтцийг илүү өндөр төвшинд гаргах шаардлага байгаа хэдий ч ялангуяа улсын үйлдвэрлэлийн салбарт эдийн засгийн өөрчлөлт төдийлөн сайн хийгдээгүй, ажилгүйдэл ихээхэн өсч байгаа зэрэг асуудлууд байсаар байна. Хөгжлийн судалгааны төвийн эдийн засагчийн хэлснээр Хятад өнөөгийн хөгжлийн стратегиа дахин арав болон түүнээс дээш жилээр хэрэгжүүлэх юм байна. Түүний хэлснээр Хятад нь хөгжлийн хурдацаа технологи өөрсдөө бүтээх бус харин түүнийг худалдан авах замаар хадгалах ажээ. Тэрээр Хятад нь сүүлийн 20 жил гадаадаас технологи худалдан авч байгаа бөгөөд цаашид ч арваас хорин жил ингэх ажээ. Түүний найдаж байгаагаар АНУ-д технологийн чиглэлээр суралцаж байгаа олон оюутнууд Хятадад буцаж ирээд Хятадын өөрийн нь өндөр технологийг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулах юм байна.

Хятадын мэргэжилтнүүдийн дунд мэдээллийн технологи, түүнийг өргөн олны дунд нэвтрүүлэхэд чиглэсэн Хятадын өрсөлдөх чадварын талаар санаа зовж байгаа явдал ч байна. Хятадын Олон улсын

судлалын хүрээлэнгийн нэгэн эрдэмтэн тэмдэглэхдээ мэдээллийн технологийн хувьсгал нь АНУ-д өндөр хурдацтай, инфляци, ажилгүйдэл багатай “шинэ эдийн засаг” бүрдүүлж байгаа бөгөөд тэгэхэд Хятад “одоо хүртэл аж үйлдвэржилтийн үе шатандаа байна” гэжээ. Түүний үзэж байгаагаар Хятад цаашид улам хоцрогдохгүй байх үүднээс аж үйлдвэржилтээ ч хэрэгжүүлж, мэдээллийн хувьсгал ч хий шаардлагатай байна. Гэхдээ түүний үзэж байгаагаар хэлэхэд амархан боловч Хятадын хувьд хүн бүрт компьютер худалдан өгч интернет ашигладаг болгоход хөрөнгө мөнгө байхгүй байна. Хятадын үйлдвэрийн газрууд технологийн шинэчлэл хийх шаардлагатай байгаа бөгөөд цаашид ажиллах хүчин дээр тулгуурласан үйлдвэрлэлийн хэлбэрээс мэдлэг дээр тулгуурласан үйлдвэрлэл явуулах шаардлагатай байна. Гэвч тэд АНУ болон бусад өндөр хөгжилтэй орнуудыг гүйцэх талаар амжилт олж чадахгүй байна. Хятадын Олон улсын судалгааны хүрээлэнгийн эдийн засагчийн хэлснээр үндэсний дотоодын нийт бүтээгдэхүүний хувьд Хятад, АНУ-ын хоорондын зөрүү ойртсон боловч бүтээгдэхүүний чанар, үйлдвэрлэлийн үр ашгийн хувьд энэ хоёр орны зааг улам ихссэн байна.

### **Судалгаа ба хөгжил, зээлийн хөрөнгийн хомсдол**

Хятадын компаниуд шинэ технологи, шинэ бүтээгдэхүүн гаргахын тулд санхүүгийн эх үүсвэрээр гачигдаж байгаа явдал Хятадын олон улсын зах зээл дээр өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх асуудалд улам төвөг учруулж байна. Хятадад ажилладаг АНУ-ын корпорацийг төлөөлдөг Хятадын нэгэн бизнесмэн ихээхэн гулрангүй байр суурьтай байлаа. Тэрээр “Хятадын компаниуд бүгдээрээ л тэмцэж л байна. Харамсалтай нь шинэ технологи хөгжүүлэх хөрөнгийн эх үүсвэр байхгүй байна. Иймээс тэд АНУ-тай компаниудтай өрсөлдөж чадахгүй” гэж байв.

Бусад орнуудтай харьцуулахад Хятадын шинжилгээ судалгааны зардал дотоодын нийт бүтээгдэхүүнтэй нь харьцуулахад ихээхэн доогуур байгаа, шинэ технологи хөгжүүлэх хөрөнгийн эх үүсвэр маш бага байгаа зэргийг Хятадын эдийн засагчид хүлээн зөвшөөрдөг. Зээлийн хөрөнгө чухал байгаа талаар болон энэ үүднээс хөрөнгө оруулалтын байгууллагуудыг үүсгэн байгуулах шаардлагатай байгааг Хятадын иргэд сайн ойлгож байна. Учир нь банкууд дээрх байгууллагуудын үүргийг сайн гүйцэтгэж чадахгүй бөгөөд тэгээд шинэ үйлдвэрлэлийн талаар тэд тийм итгэлтэй байж чадахгүй гэж үзэж байна. Хөгжлийн судалгааны төвийн нэгэн эдийн засагчийн үзэж байгаагаар Хятадын зээлийн систем, хөрөнгийн зах зээл, хөрөнгө оруулагчдыг хамгаалсан хууль цөмөөрөө ихээхэн сул тул хэн нэгэн зээлийн капиталтай байхыг хүсвэл нийгмийн дэд бүлгийн олон барилга байшинтай байх шаардлагатай болдог. Синанет зэрэг Хятадын зарим компаний ард АНУ-ын зээлийн капитал байгаа бөгөөд төв болон орон нутгийн засаг захиргаа өндөр технологи хөгжүүлэх

явдлыг дэмжих үүднээс Америкийн зээлийн капиталын маягийн зарим сан байгуулж байгаа ажээ. Гэхдээ судалгаа, шинжилгээнд зориулсан Хятадын төв засгийн газрын сан 5.5 тэрбум ам.доллар байхад Ай Би Эм ганцаараа гэхэд л шинжилгээ, судалгаанд 5 тэрбум ам.доллар байна. /Хөгжлийн судалгааны Төвийн Мэдээ, Бээжин, 2000 оны долдугаар сар/

Түүнээс гадна судалгаа, шинжилгээнд зориулсан сан байлаа ч гэсэн түүний ашиглалт тийм ч сайн биш байна. Нэгэн эдийн засагчийн хэлснээр “засгийн газарт төсөл боловсруулах мэргэжлийн хүн байхгүй байгаа хэдий ч түүнийг боловсруулж санхүүжүүлж байна гэж хэлж байна. Түүнээс гадна өөр нэг мэргэжилтэн хэлэхдээ төв засгийн газар зээл олгох компани байгуулсан боловч түүнийг мэргэжлийн хүн биш харин засгийн газрын ажилтан удирдаж байгаа тул мөнгийг үр ашиггүй зарцуулах явдал гарч байна гэжээ. Мөн төрийн өмчийн ихэнх үйлдвэрийн газрууд санхүүгийн бэрхшээлтэй тулгарч байгаа аж. Тэд ихээхэн хөрөнгө банкнаас зээлсэн тул судалгаа, шинжилгээнд зориулах хөрөнгийн эх үүсвэр олохгүй байгаа юм байна. Харин АНУ-ын компаниуд үүний эсрэгээр тухайлбал, мөнгө олсныхоо хэрээр ирээдүйн ашигаа нэмэгдүүлэхийн тулд хөрөнгө оруулалтаа улам нэмэгдүүлэх маягаар ажиллаж байна. Мөн Хятадын компаниуд шинжилгээ судалгааны ажилд хөрөнгө мөнгө зарцуулахын ач холбогдлыг ойлгохгүй байгаа явдал ч байна гэж үздэг байна. АНУ-д гэхэд шинжилгээ судалгааны ажлын нийт хөрөнгө оруулалтын 70 хувийг хувийн салбарынхан хийж байгаа аж. Түүнээс гадна Хятадын шинжилгээ судалгаанд зориулсан хөрөнгийн ихэнх нь үйлдвэрийн газрууд биш их сургууль, ШУА зэрэг байгууллагууд руу явж байна. Их сургуулиуд үндсэн судалгаа хийх талаар ихээхэн зүйл бүтээдэг хэдий ч бүтээгдэхүүний хөгжилд чиглэсэн зүйл тэр бүр хийдэггүй билээ. Хятадын хувьд хөрөнгийн ихэнх нь үргэлж алдагдалтай ажилладаг улсын үйлдвэрийн газар руу орж байгаа бөгөөд хувийн салбар руу явж байгаа хөрөнгө үгүйлэгдэж байгаа юм.

### **Мэдээллийн эрин үед төрийн хяналтыг арилгах нь**

Мэдээллийн технологийн хөгжлийн эдийн засгийн нөлөөнөөс гадна Хятадын удирдлага глобалчлалын үе дэх мэдээллийн эрин үеийн улс төр, нийгэмд үзүүлэх нөлөөний талаар бэлэн биш байгаа талаар санаа зовниж буй хүмүүс ч байна. Хятад дахь гадаадын бизнесийг төлөөлж буй нэгэн Хятад бизнесмэн: “Хятадын удирдлага улс төрийг эдийн засгаас тусгаарлаж болно гэж үздэг. Ийнхүү үзсээр Хятад сүүлийн 20 жилд амжилт олсоор ирлээ. Гэхдээ мэдээлэл, технологийн хувьсгал энэ байдалд хүчтэй нөлөө үзүүлэх болно. Интернет төрийн хяналтыг сулруулах чиглэлд нөлөөлж эхлээд байгаа, тав хүрэхгүй жилийн дотор хотын хүн ам үндсэндээ интернетэд холбогдох бөгөөд аюулаас хамгаалахын хүмүүс интернетийн мэдээллийг хэрхэн хянах талаар ярилцаж байгаа талаар сонссон” хэмээн ярьжээ. Тэрээр цааш нь

хэлэхдээ интернет маш өргөн дэлгэрч байгаа тул тэд энэ ажлыг хийх нь ихээхэн хэцүү болохыг хүлээн зөвшөөрч байгаа бөгөөд интернетийг хянах нь маш их зардал шаардаж байгаагаас гадна тэд үргэлж технологийн дэвшлийн хойно хоцорч байгаагаа ойлгож байна гэсэн байна. Мөн Хятадын нээн хуульч хэлснээр Хятадын засгийн газар интернетийн олон сувгийг хянах гэж оролдож байсан үйл ажиллагаагаа больж байгаа ажээ. Дунд сургууль, их сургууль, засгийн газар, судалгааны газрууд болон бизнесийн хүмүүс бүгдээрээ л интернет хэрэглэж, түүгээр дамжуулан өөр хоорондоо харилцаж байна. Электрон захиагаар харилцахаас гадна интернет хүмүүст янз бүрийн мэдээлэл, түүний дотор илүү чөлөөтэй мэдээлэл авахад нь ихээхэн туслаж байна. Тухайлбал, Хятадын хуулийн тухай доор хаяж 100 орчим вэб хуудас байгаа бөгөөд түүгээр дамжуулан Хятадын ямар ч хуулийг хоромхон зуур олж болж байгаа юм.

Засгийн газар технологийг бизнест ашиглах явлыг хянах оролдлогоосоо ч ухарч байна. Хятадын нэгэн бизнесмэний хэлснээр Хятадын хууль журмын дагуу гадаад, дотоодын бүх компаниуд ямар түлхүүр ашиглаж байгаа, ямар түлхүүрээр тэдгээрийн файлд орж болох зэргийг заавал мэдээлэх ёстой боловч ихэнх дотоод болон гадаадын компаниуд энэ журмыг дагахгүй байгаа ажээ. Тэрээр цааш нь хэлэхдээ засгийн газар уламжлалт хяналтынхаа аргыг ч цааш үргэлжлүүлэх боломжгүй болж байгаа юм байна. Түүний хэлснээр Засгийн газар эдүгээ ч гэсэн сонсох аппарат тавих, утас чагнах, захидал задлах зэрэг аргаа хэрэглэж байгаа хэдий ч утасны яриа болон захидал шуудангийн хэмжээ эрс нэмэгдэж байгаагаас үүдэн түүнийг гүйцэж ажиллах хөрөнгө мөнгөний эх үүсвэр дутагдаж үргэлжлүүлэхэд бэрхшээлтэй болж байгаа юм байна.

### **Нийгмийн бусад асуудлууд**

Хятадын бизнесийн бүлгийнхэн засгийн газар, намын бюрократуудыг Хятад орон глобалчлалын үйл явцад бүрэн дүүрэн оролцоход саад болж байна гэж үзэж байна. Зарим судлаачид засгийн газар глобалчлалын үйл явцад хэт сэрдсэн байдалтай хандаж глобалчлалын нийгэм, хүрээлэн буй орчны асуудалд үзүүлж буй сөрөг нөлөөг шийдвэрлэж чадахгүй байна гэж үзэж байна. Фуданы их сургуулийн эдийн засагч хэлэхдээ Хятад хэдийгээр дотооддоо глобалчлалыг шүүмжилж байгаа хэдий ч бүх чадлаараа дэлхийн эдийн засаг руу нэгдэж байна гэж байна. Хятадын өөрчлөн байгуулагчид болон глобалчлалыг эсэргүүцэгчдийн хамгийн их санаа зовоож байгаа асуудал нь Хятад орон дэлхийн эдийн засагтай интеграцчилагдах тэр хэмжээгээр Хятадын өнцөг булан бүрийн тухайлбал, эрэг хавийн болон нутгийн гүнд оршин суугчид, хот болон хөдөөгийн оршин суугчдын орлогын зөрөө улам нэмэгдэнэ гэж тооцоолж байгаад оршиж байна. Дээрх эдийн засагч ийнхүү баян, хоосны ялгаа улам нэмэгдвэл өндөр хөгжилтэй орнууд тухайлбал, АНУ-д гарсан

шиг Хятадад ч глобалчлалын эсрэг хүчтэй хөдөлгөөн өрнөхөд нөлөөлж болзошгүй гэж үзэж байна. Тэрээр цааш хэлэхдээ Сиэтлд ДХБ-ыг эсэргүүцсэн жагсаал нь глобалчлал нь бүр баян чинээлэг орнуудад ч хүмүүсийг хүнд байдалд оруулдаг юм байна гэсэн бодолд хүргэсэн гэж байна. Түүний үзэж байгаагаар дээрхийн адил асуудал Хятадад ч гарахгүй гэх газаргүй ажээ. Тэрээр Хятадад хүрээлэн буй орчин ихээхэн сүйдэж байгаад Засгийн газар хэт бага анхаарч байна гэж шүүмжилж байна. Түүний хэлснээр хүрээлэн буй орчноо сүйтгэсний төлөө Хятад орон өндөр үнэ төлөх болж байгаа аж. Тэрээр Хятадын хүрээлэн буй орчин Маогийн үед ихээхэн сүйдсэн болохыг хүлээн зөвшөөрсөн боловч гол асуудал глобалчлалын үед л гарч байна гэж үзэж байна.

Эцэст нь тэмдэглэхэд Хятадын судлаачид албаны хүмүүс глобалчлалаас үүдэн үүсэх ажилгүйдлийн асуудал нийгэм, улс төрийн тогтвортой байдалд нөлөөнө гэдгийг хүлээн зөвшөөрч байна. Хятадын орчин үеийн олон улсын харилцааны хүрээлэнгийн ахлах мэргэжилтэн Хятад нь глобалчлалын асуудлыг авч үзэхдээ зөвхөн эдийн засгийн асуудал төдийгүй болзошгүй нийгмийн замбараагүй байдал үүсэхийг үгүйсгэж болохгүй гэж үзэж байна. Ялангуяа Хятад нь улсын үйлдвэрийн газрыг оролцуулан эдийн засгаа өндөр төвшинд гаргах ёстой боловч өнөөг хүртэл тэгж чадаагүй байгаа нь анхаарах ёстой асуудлын нэг болж байна гэж тэрээр үзэж байна. Тэрээр болон бусад судлаачдын үзэж байгаагаар улсын үйлдвэрийн газрыг өөрчлөх явцад үүсэж байгаа ажилгүйдлийн асуудал тогтвортой байдалд нөлөөлж болзошгүй хамгийн том аюул юм байна. Тэдгээрийн үзэж байгаагаар зарим улсын үйлдвэрийн газрууд дампуурч бүх ажилчидаа халж зарим нь өрсөлдөөнийг сөрж үлдэх үүднээс орон тоогоо ихээхэн хасахад хүрэх аж.

Үр ашигтай нийгмийн хамгааллын систем байхгүй байгаа өнөөгийн нөхцөлд ажилгүйдлийн асуудлын нөлөө улам хурцаар тавигдана гэж үзэж байна. Засгийн газрын зүгээс нийгмийн даатгалын систем бүрдүүлэх чиглэлээр хүчин чармайлт гаргаж байгаа хэдий ч өнөөг хүртэл үр дүн бага байгаа ажээ. Хөгжлийн судалгааны төвийн ахлах эдийн засагчийн үзэж байгаагаар Хятадын нийгмийн даатгалын систем тэтгэвэр болон ажилгүйдлийн даатгал төлөх хөрөнгө мөнгө хомс ажээ. Энэхүү эдийн засагчийн хэлснээр энэ бүхний шалтгаан нь хэдэн жилийн өмнө Хятадын засгийн газар үйлдвэрийн газруудаас нийгмийн даатгалын санг авч шинэ төслүүдэд хөрөнгө оруулалт хийсэн бөгөөд уг хөрөнгө оруулалт нь ихээхэн үр ашиг муутай ажиллаж байгаатай холбоотой ажээ. Засгийн газар уг сангийн хөрөнгийг буцааж үйлдвэрийн газруудад нь өгөх ёстой боловч ингэх санхүүгийн эх үүсвэр байхгүй болоод байгаа ажээ.

Хятадын үндсэрхэг үзэлтэнгүүд болон үзэл сурталтангууд Хятад бодлогоо өөрчилж, өөрийгөө глобалчлалын үйл явцаас гаргаж социалист



мөн чанар, тогтолцоо, эдийн засагт тулгуурлан глобалчлалын аюул заналаас гарах ёстой гэж үзэж байна. Гэхдээ Хятадын олон өөрчлөн байгуулагчид глобалчлалын болзошгүй нийгэм, улс төр, эдийн засгийн сөрөг нөлөөллөөс гарах буюу түүнийг тойрон өнгөрөх цорын ганц зам эдийн засаг, улс төрийн өөрчлөлтийн үйл явцыг түргэвчилж Хятадыг дэлхийн хамтын нийгэмлэгтэй аль болох хурдан хугацаанд интеграцчилах явдал гэж үзэж байна. Нэгэн өөрчлөн байгуулагчийн төлөөлөгч “Хятад нь ямар ч боловсрол, нийгмийн хамгаалалтын системгүй хурдан өсөн өсөн нэмэгдэж байгаа ажилгүйдлээс үүдэн тэсрэх “томоохон бөмбөг” дээр сууж байна гэж анхааруулж байна. Энэхүү бөмбөгийг цэнэггүй болгох эдийн засгийн чухал алхамын нэг бол тэртээ тэргүй мөхөх нь тодорхой байгаа улсын үйлдвэрийн газруудыг хувьчлах явдал гэж дээрх эрдэмтэн үзэж байна. Тэрээр цааш ярихдаа улс төрийн хувьд Хятад удирдлагын арга барилаа өөрчлөх ёстой гэж үзэж байна. Улс төрийн системийг бүхэлд нь өөрчилж түүнд цөөн тооны элитийн давхарга бус нийгэм бүхэлдээ оролцох нөхцөлөөр хангах ёстой бөгөөд Хятадын ард түмэн олон ургальч, ил тод систем үгүйлж байна гэж тэрээр үзэж байгаа ажээ. Түүний үзэж байгаагаар ирэх арван жилийн дотор Хятад олон намын системтэй болж ХКН тэдгээрийн дунд хамгийн том нь байхаар зохион байгуулах ёстой юм байна.

## ДҮГНЭЛТ

Хятадын шинэ удирдлага глобалчлалын үйл явцад Хятадын оролцоог улам нэмэгдүүлэхийн төлөө байна гэж албаны хүмүүс болон судлаачид нь үзэж байна. Тэдгээрийн үзэж байгаагаар Хятадын удирдлагын энэхүү хүсэл эрмэлзлэл Хятад, АНУ-ын харилцаа ихээхэн хурцадмал, тэгээд ч АНУ-ын стратегийн сонирхолын талаар Хятад ихээхэн эргэлзэж байсан үе болох өнгөрсөн онд ДХБ-д элсэхдээ АНУ-д ихээхэн буулт хийсэн явдлаас тод харагдаж байгаа ажээ. Тэр үед Хятадын удирдагчид зөвхөн АНУ-тай хамтран ажиллах асуудал төдийгүй АНУ-ын Хятадыг ноёрхох зэвсэг хэмээн үзэж байсан глобалчлалын үйл явцаас ухрахыг шаардаж байсан дотоодын хүчний ихээхэн хүчтэй шахалтанд орж байсан цаг үе байлаа. Гэвч Хятадын удирдагчид үндсэрхэг үзэлтэнгүүд, АНУ-ын эсрэг шахалт, ялангуяа глобалчлал болон ДХБ-ын эсрэг даралт шахалтыг давж чадсан юм. Тэд хэрэв Хятад эдийн засгийн хөгжлийн зорилгодоо хүрэхийг хүсч байвал глобалчлалын үйл явцад оролцохоос өөр зам байхгүйг хүлээн зөвшөөрч буй гэсэн дүгнэлт хийж болох юм. Түүнээс гадна Хятадын удирдагчид глобалчлалын тулгамдсан асуудлыг амжилттай шийдвэрлэх нь Хятад орны олон асуудал, түүний дотор эдийн засгийн бус асуудал болох Тайваний

асуудлыг шийдвэрлэх зайлшгүй нөхцөл гэсэн дүгнэлтэд хүрсэн бөгөөд хэрэв глобалчлалын өмнө Хятад амжилт олохгүйд хүрвэл түүний эдийн засаг уналтанд орж, нийгмийн эмх замбараагүй байдал үүсэж, Тайванийг өөрөөсөө алдахад хүрэх болно гэдгийг ч ойлгож байна.

Хятадын ихэнх удирдах хүмүүс, өөрчлөлт шинэчлэлийг дэмжиж албаны хүмүүс болон судлаачид глобалчлалын талаархи “хоёр иртэй сэлэм” үзлийг хүлээн зөвшөөрч байгаа хэдий ч тэд Хятад улс ДХБ-ын өмнө хүлээж байгаа үүргээсээ эхлэн глобалчлалын өмнө хүлээх үүргээ амжилттай биелүүлнэ гэдэгт итгэлтэй байна. Түүнээс гадна глобалчлалыг урагшлуулахыг дэмжиж байгаа хүчин ихээхэн байгаа бөгөөд түүний эдийн засаг, улс төр, нийгмийн сөрөг нөлөөг гаргахгүй байхаар урагшлах арга хэмжээ авахад бэлэн байгааг тэд илэрхийлж байна.

Консерватив үндсэрхэг үзэлтэнгүүд болон хэт зүүний талыг баримтлагчид Хятад үндэстний онцлог, бие даасан байдал, улс төрийн системд АНУ-ын тэргүүлсэн глобалчлал занал учруулж байна гэж үзэж Хятад глобалчлалаас ухарч амжиргааны төвшин буурахад хүргэлээ ч гэсэн социалист эдийн засаг, моралд илүү анхаарахыг уриалж байна. Тэд мөн Хятадын хөгжил цэцэглэлийг хойш чангаадаг байлаа ч гэсэн Тайванийг өөртөө нэгтгэхийн төлөө дайнд мордох нь зүйтэй гэж үзэж байна.

Өнөөгийн байдлаар глобалчлалын эсрэг үзэл бодлоо илэрхийлж байгаа АНУ-ын эсрэг үзэлтэнгүүдийн санаа бодлыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр өргөн дэлгэрүүлж байгаа хэдий ч тэдгээрийн улс төрийн бодлогод үзүүлж байгаа нөлөө хязгаарлагдмал байна. Түүнээс гадна глобалчлалыг эсэргүүцэгчдийн үзэл бодлын шалтгаан, эрхэмлэж байгаа болон санаа зовниж байгаа зүйл, улс төрийн зорилго өөр өөр байна. Үндэсэрхэг үзэл болон үзэл суртлын шалтгаанаар глобалчлалыг эсэргүүцэж байгаа хүчин ач холбогдол өгч байгаа асуудал, зорилгоороо өөр хоорондоо бас ялгаатай байна. Тэд глобалчлал болон ДХБ-ын сөрөг нөлөөнөөс өөрсдийн эдийн засгийн ашиг сонирхолын улмаас эмээж байгаа хүчнүүдтэй холбоогүй байна. Түүнээс гадна сүүлийн бүлэг глобалчлалыг эсэргүүцэх нь аюултай гэдгийг мэдэрч байгаа бөгөөд харин зөвхөн энэ үйл явцыг ДХБ-ын журмыг биелүүлэх үйл явцыг удаашруулах замаар олон улсын болон дотоодын өрсөлдөөн хүчтэй болсноос амсаж буй хохиролоо нөхүүлэхийг зорьж байна. Нийт ард түмний хувьд глобалчлалын үйл явцыг шүүмжлэгчид болон засгийн газрын бодлогыг дэмжиж байгаа боловч өнөөгийн радикал үзэлтэнүүдийг дэмжихгүй байна. Гэвч Хятадын дотоод болон гадаад бодлогод глобалчлалын эсрэг хүчний нөлөө ирэх хэдэн жилийн дотор нэмэгдэх төлөвтэй байгааг глобалчлалыг дэмжигчид сануулж байна. Энэ байдал ялангуяа Хятад ДХБ-д орсноор түүний эдийн засгийн хөгжил удааширвал гарч болзошгүй гэж үзэж байна.

Мөн Хятад, Америкийн харилцаа, ялангуяа Тайваний асуудлаас үүдэн муудвал глобалчлалын эсрэг үндсэрхэг үзэлтэнгүүд ихээхэн дэмжлэг авч болзошгүй ажээ.

Хэрэв АНУ болон дэлхийн эдийн засаг удааширвал өөрчлөлтийн үйл явц болон ДХБ-ын өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх үүднээс авах ёстой төвөгтэй арга хэмжээг амжилттай хэрэгжүүлж чадах эсэх талаархи Хятадын удирдагчдын чадавхийг ойрын үед шалгах цаг ирнэ гэж үзэж байна. Хэрэв АНУ-ын эдийн засаг удааширвал Хятадын экспортын барааны зах зээл хумигдаж гадаадын хөрөнгө оруулалт буурч улсын үйлдвэрийн газрыг шинэчлэхтэй холбогдон гарч байгаа эдийн засаг, нийгмийн асуудал хуримтлагдаж, ДХБ-ын нөлөөгөөр өрсөлдөөн улам хурцадах болно. Энэ нөхцөл байдал нь глобалчлалын эсрэг хүчин, үндсэрхэг үзэлтэнгүүдийг дэвэргэж тэдгээрийн үзэл бодлыг дэмжигчид нэмэгдэж Хятад илүү өөрийнхөө хүчинд тулгуурласан замыг сонгоход хүргэж болзошгүй. Энэ нөхцөл байдалд глобалчлалын эсрэг хүчин өргөн олны дургүйцлийг ашиглаж глобалчлалын тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн өөрчлөн байгуулагчдын бодлогод саад болохыг оролдож мэдэх юм. Хэрэв ийм байдал үүсвэл улам шуурхай арга хэмжээ авах шаардлага гарах болно. Хятадын удирдлага глобалчлалын үйл явцтай холбогдуулан хэцүү ч гэсэн авах ёстой арга хэмжээг авахгүй бол алс хэтдээ эдийн засаг, нийгэм, улс төрийн илүү төвөгтэй хямралд хүргэж болох талтай.

Хятад нь эдийн засгийн хувьд үлэмж хөгжлөө ч гэсэн глобалчлалын үйл явц Хятадыг оролцуулан хөгжиж буй орнууд болон хөгжилтэй орнуудын хоорондын ялгааг улам нэмэгдүүлнэ гэж санаа зовж байна. Үүний зэрэгцээ хамгийн чухал нь АНУ Хятадыг эдийн засаг, технологи, цэргийн хүчний хувьд тэргүүлж ирэх хэдэн арван жилийн дотор Хятад, АНУ-ын хоорондын тэнцвэргүй байдлыг улам нэмэгдүүлнэ гэж үзэж байна. Энэ бүхний нөлөөгөөр хүчний тэнцвэрийн хувьд Хятад АНУ-д байр сууриа алдаж болзошгүй. Энэ нь Хятадын үндсэрхэг үзэлтэнгүүд болон глобалчлалыг эсэргүүцэгчдийн дургүйцлийг улам ихээр төрүүлэхгүй гэх газаргүй.

Хятад дахь үндсэрхэг үзэлтэнгүүд, глобалчлалын эсрэг үзэл нь Хятадын удирдагчдад улам их даралт үзүүлэх төлөвтэй байна. Иймээс Хятадын удирдагчид Хятад, АНУ-ын харилцаанд илүү буулт хийх боломжоор хязгаарлагдаж байгаа юм. Хятадын зарим удирдлага өөрийн үндсэрхэг болон глобалчлалын эсрэг үзэл бодолтонгууд дээр дөрөөлж Хятадын дотоодын зөрчлийг АНУ-д тохож дотоодын асуудлаас олон нийтийнхээ анхаарлыг холдуулах үүднээс АНУ болон Тайваний эсрэг хатуу бодлого явуулахыг уриалж байна.